

БАТЛАВ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД



Б.ЭНХБАЯР

“АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах болсон үндэслэл

Авлигын эсрэг хуулийн 2¹ дүгээр зүйлийн 2^{1.1} дэх хэсэгт “Улсын Их Хурал Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах бөгөөд түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт заасан хугацаагаар батална.” гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-г баталсан. Уг тогтоолын 2-т Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгаж байхыг, “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан шаардлагыг ханган боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Иймд Авлигын эсрэг хууль болон Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолд заасныг үндэслэн “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулна.

Хоёр.Тогтоолын төслийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

“Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлд дараах агуулгыг тусгана.

1.Тогтоолын хавсралтаар Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлахаар;

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газарт, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Авлигатай тэмцэх газарт даалгахаар;

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд даалгахаар тусгана.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Тогтоолын төсөл батлагдсанаар Авлигын эсрэг хууль болон Монгол Улсын Их

хөтөлбөр"-ийн хэрэгжилт хангагдах боломж, нөхцөл бүрдэнэ.

Ингэснээр "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төрийн бүтээмжийг сайжруулах зорилго бүхий "Шинэ сэргэлтийн бодлого"-той уялдуулан үндэсний шударга ёсны тогтолцоог бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэргийг бууруулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг бэхжүүлэх, нийгмийн шударга ёсыг эрхэмлэсэн хандлагыг төлөвшүүлэн, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх ач холбогдолтой болно.

Дөрөв.Тогтоолын төслийг батлахтай холбогдуулан цаашид шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн талаар

Тогтоолын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн боловсруулна.

Тогтоолын төслийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомж байхгүй болно.

-----oOo-----